



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН ТОЙМ

ДЭЛХИЙН БАНК

2009 оны 6-р сар



Дэлхийн Банкнаас эрхлэн гаргадаг *Монгол Улсын Эдийн засгийн сарын тойм* нь тус улсын нийгэм, эдийн засгийн сүүлийн үеийн үзүүлэлтүүд, бодлогыг тоймлон хүргэдэг баримт бичиг бөгөөд Дэлхийн Банкнаас Монгол Улсад явуулж буй ажиллагааны үр дүнг давхар танилцуулдаг. *Монгол Улсын Сарын тоймыг* бэлтгэхэд Дэлхийн Банкны Үүн Ази, Номхон далайн бүсийг хариуцсан дэд захирлын дэргэдэх Ядуурлыг бууруулах, Эдийн засгийн удирдах салбарын нэгжийн мэргэжилтнүүдийн зэрэгцээ Монгол Улсыг хариуцсан багийн бусад гишүүд голлох үүрэгтэйгээр оролцсон болно. Сарын тоймтой холбоотой аливаа асуулт, саналын талаар Шийлэгмаагийн Алтанцэцэг (ashiilegmaa@worldbank.org)-г хандана уу. Мөн <http://www.worldbank.org.mn> хаягаар орж хуулбарыг татаж авах боломжтой.

Гарчиг

Хэсэг:	Хуудас
1. Удиртгал	3
2. Төсвийн тэнцэл	3
3. Гадаад салбар	7
4. Санхүүгийн салбар	9
5. Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдэл	12
6. Дүгнэлт	15
Хүснэгт:	
1. 4-р сарын гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого нэмэгдсэн	3
2. 2008 оны түвшинтэй харьцуулахад төсвийн зарлага бага зэрэг өссөн	5
3. Барааны экспортод гарч буй өөрчлөлтийн гол хүчин зүйлүүд	8
4. Экспорт, улс орноор	8
5. Барааны импортод гарч буй өөрчлөлтийн гол хүчин зүйлүүд	8
6. Хүнсний барааны үнэ өссөн	15
7. Газрын тосны үнэ буурч албан бус уул уурхайн зарим өртөг зардлын өсөлтийг хязгаарлав..	15
8. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	16
Зураг:	
1. Зэс, алтны үнэ түр сэргэж, гэнэтийн ашгийн татварын орлого төвлөрүүлж байна	4
2. 2005 оны түвшинтэй харьцуулахад 2008 онд эрчим хүчний тасалдлын үргэлжлэх хугацаа уртассан	6
3. Эрчим хүчний илүүдэл нөөц ирэх жилүүдэд багасах болно	6
4. Төсвийн нийт алдагдал ДНБ-ий 8.2 хувьд хүрэв	7
5. Импортын уналт экспортоос түрүүлж байгаагаас гадаад худалдааны тэнцэл сайжирч байна	7
6. Төгрөгийн ханш тогтворжиж, Монголбанк гадаад валютын нөөцөө хуримтлуулж байна	9
7. Инфляци буурахтай зэрэгцээд Монголбанк бодлогын хүүгээ буурууллаа	9
8. Төгрөгийн харилцах хадгаламжийн хэмжээ буурч гадаад валютын харилцах хадгаламж өссөн	10
9. Чанаргүй зээл, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн багц нэмэгдэж нийт зээлийн өрийн үлдэгдлийн 18.1 хувьд хүрсэн	10
10а. Боловсруулах, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт олгосон зээлийн өрийн үлдэгдэл хамгийн өндөр чанаргүй багц, хугацаа хэтэрсэн үндсэн төлбөртэй байна	11
10б. Тэгээд чанаргүй зээлийн багц, хугацаа хэтэрсэн зээлийн ихэнх хэсэг эдгээр салбарт ногдож байна	11
11. Банкууд зээл гаргахын оронд төвбанкны үнэт цаасыг түлхүү худалдан авч байна	11
12а. Бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхай, барилга, боловсруулах салбарт шинээр олгох зээл эрс багасч	12
12б. ... нийт зээлийн багцын ихэнх хэсэг чанаргүй зээлийн багц өндөртэй байгаа салбаруудад төвлөрч байна	12
13. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл тогтвортой байгаа ч боловсруулах салбарын үйл ажиллагаа хурдацтай хумигдсаар байна	12
14. Аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого, татварын өмнөх ашиг, татвар төлөлт буурсан	13
15. Барилга, уул уурхай, байгалийн хий, түлш, нүүрсний бөөний худалдааны аж ахуйн нэгжүүдийн орлого хамгийн ихээр унажээ	13
16. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо эрс өсөв	14

Шигтгээ:

1. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ 6
2. 2009 оны эхний улиралд аж ахуйн нэгж байгууллагын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 хувиар буурчээ13
3. Монгол Улсын эдийн засгийн сааралтын нийгэм, ядуурлын үр дагавар15

1. Удиртгал¹

Эдийн засгийн сааралтын юлөөлөл эдийн засаг дая аар мэдрэгдэж, уналтын хурдац олон салбарт саарсан хэдий ч цаашид банкны салбарт эрсдэл учирч болзошгүй байна . 4-р сартай харьцуулахад нэгдсэн төсвийн алдагдал 5-р сард бага зэрэг нэмэгдсэн боловч төсвийн орлого сайжирсан байна . Импортын уналт экспортынхоос хурдан байгаа учраас худалдааны тэнцэл сайжирч байна. Төгрөгийн ам. доллартай харьцах ханш тогтворжихтой зэрэгцээд Монголбанкинд гадаад валютын нөөцөө хуримтлуулах боломж бүрдэв.

Салбарын салбарын талбар дээр инфляци буурч (ерөнхийдөө эдийн засгийн сааралттай холбоотой) байгааг харгалзан үзээд Монголбанк бодлогын хүүгээ дахин бууруулсан. Арилжааны банкин дахь харилцах хадгаламжийн нийт хэмжээ нэмэгдсэн хэдий ч чанаргүй зээлийн багц, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдэж байна. Банкууд зээл гаргах сонирхолгүй байгаа бөгөөд оронд нь төвбанкны эрсдэл багатай үнэт цаасыг худалдан авч байна. Зээлийн энэхүү хямрал боловсруулах салбарын уналтыг улам их даамжруулж байна. Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ тодорхой хэмжээгээр сэргэсний ачаар зөвхөн уул уурхай, олборлох салбар эдийн засгийг тэтгэж байна. Ийм цагүеийн жишгээр аж ахуйн нэгжийн орлого, татвар төлөлт эрс буурсан дүнтэй байна. Албан болон албан бус секторын аль алинд ажилгүйдэл нэмэгдсэн.

2. Төсвийн тэнцэл²

Хүснэгт 1. 4-р сарын гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого нэмэгдсэн

	2008 оны нийт орлогод эзлэх хувь (%)	2008 оны 4-р сараас 2009 оны мөн үе хүртэлх өөрчлөлт (%)	2008 оны 5- р сараас 2009 оны мөн үе хүртэлх өөрчлөлт (%)
Нийт орлого, тусламжийн дүн	100.0	-31.4	-22.8
Татварын орлого	87.6	-35.0	-29.8

¹ Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Сангийн яамнаас хамгийн сүүлд гаргаж өгсөн буюу 2009 оны 1-р улирал, 5-р сарын мэдээ болон тайланд дурьдагдах бусад эх сурвалжаас гаргаж өгсөн мэдээ мэдээлэл дээр үндэслэж тооцоо шинжилгээг хийв.

² Төсвийн шинэ тодотголыг УИХ-д тун удахгүй өргөн барихаар төлөвлөж байна.

4-р сарыг үйлдвэрлэлтэй

харьцуулахад өсвийн орлого сайжирсан


2009 оны 5-р сарын гүйцэтгэлийг 2008 оны мөн үетэй харьцуулбал өсвийн нийт орлого 22.8 хувиар буурчээ (Хүснэгт 1). 2009 оны

ААНБ-ын орлогын татвар	11.7	-45.6	-45.5
Хүн амын орлогын татвар	4.7	16.5	12.2
Гэнэтийн ашгийн татвар	18.0	-91.8	-86.9
НДШ	10.4	-6.2	16.6
НӨТ	16.5	-18.5	-7.4
Онцгой албан татвар	8.3	-11.1	-8.9
Импортын татвар	6.6	-29.8	-29.5
Нөөц ашигласны төлбөр	5.1	-53.2	-46.9
Татварын бус орлого	11.5	-4.4	26.8
Ногдол ашиг	1.5	59.5	182.3

Тайлбар: Улсын төсөв, орон нутгийн төсөв, МУ -ыг хөгжүүлэх сан, нийгмийн даатгалын санг багтаасан нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд.
Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн Банк

4-р сард өсвийн нийт орлого 2008 оны мөн үетэй харьцуулахад 31.4 хувиар буурч байсныг харгалзан үзвэл 5-р сарын гүйцэтгэл сайжирсан байна. Орлогын өөрчлөлтийг сараар (2009 оны 4-р болон 5-р сар) авч үзвэл сарын өсөлтийн ихэнх хэсгийг гэнэтийн ашгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэл, нэмэгдсэн өртгийн татвар, онцгой албан татварын орлого бүрдүүлжээ.

Зураг 1. Зэс, алтны үнэ түр сэргэж, гэнэтийн ашгийн татварын орлогыг бүрдүүлж байна.



Тайлбар: Гэнэтийн ашгийн татвар оногдуулах нэг тонн зэсийн үнэ болох 2600 ам. доллар, нэг унци алтны үнэ болох 850 ам. долларыг тасархай шугамаар харуулав.

Сүүлчийн ажиглалт: 2009 оны 6-р сарын 19.

Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн Банк

давсан. 2009 оны 1-р сарын дундаас хойш алтны үнэ ч гэсэн гэнэтийн ашгийн татвар оногдуулах босго болох нэ унци нь 850 ам. долларад байлаа (Зураг 1). Эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ сүүлийн үед өссөн хэдий ч эрдэс баялгийн орлого 2009 онд 2007, 2008 оны түвшинтэй харьцуулахад үлэмж доогуур байх төлөвтэй байна. Тухайлбал, 2009 оны эхний таван

2009 оны 4-р сард мөнх оны мөн үетэй харьцуулахад гэнэтийн ашгийн татварын орлого нилээд их хэмжээгээр буюу 91.8 хувиар буурч байсантай харьцуулахад орлогын бууралт 5-р сард багассан (-86.9 хувь) байна. Нэг тонн зэсийн үнэ өнгөрсөн 12-р сард 2,600 ам. доллар буюу гэнэтийн ашгийн татвар оногдуулах босгоны хүртэл унасан үвшнээсээ сэргэн, 5-р сард энэхүү өсөлт үргэлжилж 6-р сарын үед нэг тонн зэсийн үнэ 6,000 ам. долларын түвшинг түр

сарын байдлаар гэнэтийн ашгийн татвар³ өнц ашигласны төлбөрийн орлого ³ нийт төсвийн орлогын дөнгөж 7 хувийг бүрдүүлсэн юм. 2007, 2008 онуудад энэ орлого 18, 23 хувьтай тус тус тэнцэж байв.

Монгол Улс үйлдвэрлэсэн зэсийнхээ ихэнх хэсгийг БНХАУ уруу экспортлодог⁴ учраас тэнд болж буй өөрчлөлтийг тогтмол хянаж байх нь зүйтэй. Дэлхийн Банк БНХАУ-ын эдийн засаг 2009 онд 6.5 хувиар өснө гэж байсан төсө өллөө өөрчилж 7.2 хувь⁵ болгосон нь тус улсын эдийн засгаа дотооддоо тэлэх бодлого тооцоолж байснаас илүү их нааштай үр нөлөө авчрахтай холбоотой юм. Эдийн засгаа тэлэх үрэх бодлогын хүрээнд дэд бүтцийн хөгжилд түлхүү анхаарч захиргаадалтын жоронго оруулалтыг нэмэгдүүлж зэсийн үнэ дэлхийн зах зээл саяхан өсөх нэг шалтгаан болсон.⁶ Гэхдээ дэлхийн эдийн засаг сэргэтэл БНХАУ-ын эдийн засгийн өсөлт маш өндөр түвшинд хүрч чадахгүй бололтой.

Төсвийн нийт зардал нэрлэсэн дүнгээрээ харьцангуй тогтмол байна

2009 оны эхний таван сарын гүйцэтгэлийг 2008 оны мөн үетэй харьцуулахад төсвийн нийт зарлага, цэвэр зээл нэрлэсэн дүнгээрээ бага зэрэг нэмэгдэж бодит дүнгээрээ 13 хувиар буурчээ (Хүснэгт 2). Нийгмийн даатгалын сан (тэр дундаа тэтгэврийн сан), нийгмийн халамжийн сангийн ашиглалт 2008 оны үвшиндээ байна. Нийгмийн халамжийн сангийн томоохон хэсэг болгүүхдийн мөнгийг 2009 оны 3-р сард хийсэн тодотголын дагуу олгож байна. Дотоод хөрөнгө оруулалт өмнөх оны үвшингээс үлэмж доогуур байна (гэхдээ энэ бууралтын гадаад эхүүсвэрийн хөрөнгө оруулалтын өсөлт нөхөж байгаа).

Дэд бүтцийн засвар үйлчилгээг багтаадаг их засвар 2008 оны гүйцэтгэлээс 79 хувиар доогуур үзүүлэлттэй байна. 2009 оны 5-р сард их засварын гүйцэтгэл өмнөх сарын гүйцэтгэлээс сайжирсан нь сайшаалтай хэрэг. Замын сан, дотоод хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр нилээд их хэмжээний их засварын ажил үйцэтгэдэг учраас их засвар гэдэг төсвийн ангилал нь засвар үйлчилгээний нийт зарлагыг бүрэн дүүрэн тусгаж чаддаггүй. Дэлхийн Банкны хувьд суурь дэд бүтцийн засвар үйлчилгээнд ихээхэн ач холбогдолөгдөг учраас цаашид хийгдэх бодлогын шинэчлэлийн гол тэргүүлэх чиглэл нь засвар үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эх үүсвэрийг гаргаж өгөх явдал гэж үзэж байгаа. Эдийн засгийн сааралтын үед суурь дэд бүтцэд шаардлагатай засвар үйлчилгээг

³ Гэнэтийн ашгийн татвар, нөц ашигласны төлбөрөөс гадна уул уурхайн компаниудын төсөвт төлж буй аж ахуйн нэгж байгууллагын ашгийн татвар, ногдол ашгийн өлбөр нь эрдэс баялгийн орлогод багтана. Гэхдээ эдгээр үзүүлэлтүүдийг сараар задалж гаргадаггүй.

⁴ Экспортын нийт орлогын 65 хувийг БНХАУ-д гаргаж буй экспорт бүрдүүлж байгаа бөгөөд түүний тал хувнаа зэсийн экспорт эзэлж байна.

⁵ БНХАУ-ын эдийн засгийн улирлын тоймын хамгийн сүүлчийн дугаарт үндэс лэв, 2009 оны 6-р сар, <http://www.worldbank.org/cn>

⁶ Монгол Улсын эдийн засгийн 2009 оны 5-р сарын тоймын Шигтгээ 1-д (<http://www.worldbank.org/mn>) зэсийн үнийг тодорхойлогч хүчин зүйлийн талаарх шинжилгээг харуулсан.

хангаж өгөх нь эн тэргүүнд шийдвэрлэх асуудал байх ёстой. Тухайлбал, эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээнд зориулсан төсвийн хувиарлалтын хандлагыг харахад санаа зовох нэг сэдэв болж байна (Шигтгээ 1).

Хүснэгт 2. 2008 оны түвшинтэй харьцуулахад төсвийн зардлага бага зэрэг өссөн.

	2008 оны зарлагад эзлдээх хувь (%)	2008 оны 4-р сараас 2009 оны мөн үе хүртэлх өөрчлөлт (%)	2008 оны 5-р сараас 2009 оны мөн үе хүртэлх өөрчлөлт (%)
Нийт зарлага ба цэвэр зээл	100.0	-3.6	1.5
Урсгал зарлага	71.1	0.4	2.7
Цалин хөлс	22.1	9.5	8.2
Бараа үйлчилгээний худалдан авалт	19.8	-3.4	-8.6
Эрчим хүчний татаас	0.6	20.7	27.5
Нийтийн тээврийн татаас	0.5	21.7	10.4
Нийгмийн даатгалын сан	14.9	-11.7	2.0
Нийгмийн халамжийн сан	8.8	-0.8	2.0
Хөрөнгө оруулалтын зарлага	25.4	-6.6	-5.7
Дотоодын хөрөнгө оруулалт	19.4	-17.6	-18.0
Их засвар	1.1	-93.7	-79.0

Тайлбар: нэгдсэн төсөвт улсын төсөв, орон нутгийн төсөв, МУХС, НД сан багтана.

Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн Банк

Шигтгээ 1. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ


Эдийн засгийн сааралтын эрхэд Монгол Улс ын хувьд ашиглалтанд байгаа эрчим хүчний сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, Өмнөд Говийн бүсэд шинээр хөгжихөөр төлөвлөгдсөн уул уурхайн төслүүдийн эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээний хүчин чадлыг шинээр бий болгоход хөрөнгө оруулах нь чухал ач холбогдолтой байна. Эрчим хүч ойр ойрхон тасалдах нь үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ Монгол Улсад болдог хатууөвлийг харгалзаж үзвэл хамгийн чухал нь хүмүүсийн амьжиргааг доройтуулах болно . Эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхгүйгээр Монгол Улсын эрчим хүч ний эрэлт хэрэгцээ хэдхэн жилийн дараа нийдүүлэлтээсээ давж, тус улсад ойрын ирээдүйд эрчим хүчний тасалдал үүсэх эрсдэлд тулгараад байна.

Өнгөрсөн цөөн хэдэн жилд эрчим хүчний тасалдал нэмэгдсээр иржээ (Зураг 2). 2006 онд нэг үнд ногдох эрчим хүчний тасалдлын үргэлжлэх хугацаа 4,857 минут байсан бол 2008 онд 7,226 минут болж 49 хувиар өсчээ (таван өдөртэй тэнцэнэ). Энэ нь нэг үнд ногдох эрчим хүчний тасалдлын тоо олширч, нэг тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа нь уртасантай шууд холбоотой.

Өмнөд Говийн дэд бүтцийн стратегийн баримт бичгийг боловсруулахад Засгийн газарт туслалцаа дэмжлэг үзүүлэх хүрээнд Дэлхийн Банкнаас хийсэн хамгийн сүүлийн шейин симуляцийн үр дүнгээс харахад хүчин чадал хангалтгүй байгаагаас ойрын ирээдүйд эрчим хүчний тасалдал үүсэх магадлал өндөр байна. Уул уурхайн төслүүд ашиглалтанд орж, орд газрууд ойрын жилүүдэд эдийн засгийн эргэлтэнд орох үед эрчим хүчний эрэлт хэрэгцээ нэмэгдэх төлөвтэй байна (Зураг 3). Үүнтэй зэрэгцээд одоо ашиглалтанд байгаа нэг дулааны цахилгаан станцыг ажиллагаа зогсох гэж байгаа . Дулааны цахилгаан станц шинээр барихгүйгээр Монгол Улс ОХУ, БНХАУ-аас эрчим хүч импортлохоос өөр аргагүй болно. Зарим хэрэгцээгээ импортоор хангасан ч гэсэн гэнэтийн осол доголдол, оргил эрэлтийн үед эрчим хүчний илүүдэл нөөц ойрын жилүүдэд хүрэлцэхгүй болж ирэх магадлалтай байна.

Зураг 2. 2005 оны түвшинтэй харьцуулахад 2008 онд эрчим хүчний тасалдлын үргэлжлэх хугацаа уртассан


Нэг хэрэглэгчид ногдох эрчим хүчний тасалдал, минутаар



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах газар

Зураг 3. Эрчим хүчний илүүдэл нөөц ирэх жилүүдэд багасах болно

Мегаватт



Эх сурвалж: Economic Consulting Associated, Дэлхийн Банк

Эх сурвалж: Economic Consulting Associated; Дэлхийн Банк (2009), *Өмнөд Монголын дэд үйлцийн стратегийн баримт бичиг*, хэлэлцүүлэгт зориулсан төсөл, 2009 оын 3-р сар; Дэлхийн Банк

6-р сарын байдлаар өмнөх 12 сарын төсвийн дундаж алдагдал ДНБ-ий 8.2 хувьтай тэнцэж байна

Өмнөх 12 сарын төсвийн тэнцлийн нийлбэрийг (улирлын юлөөлөл төсвийн үзүүлэлтүүд дээр өндөр байдаг учраас) тооцож үзвэл төсвийн өмнөх 12 сарын алдагдал 5-р сард 505 тэрбум өгрөгт хүрсэн нь 2008 оны ДНБ-ий 8.2 хувьтай тэнцэж байна (Зураг 4).

Зураг 4. Төсвийн тэнцэл ДНБ-ий 8.2 хувьд хүрэх




Тайлбар: 2008 оны үнээр ДНБ 6,130 тэрбум төгрөгт хүрсэн.
Эх сурвалж: Сангийн яам, Дэлхийн Банк

3. Гадаад сектор

Импортын уналт экспортын уналтаас түрүүлж байгаа учраас гадаад худалдааны тэнцэл сайжирч байна

Зураг 5. Импорт экспортын уналтаас ихээр унаж байгаа учраас гадаад худалдааны тэнцэл сайжирч байна



Тайлбар: улирлын хүчин зүйлийн нөлөөллийг арилгах үүднээс өмнөх 12 сарын нийлбэрийг авав.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк

сайжирсан байна (Зураг 5).

Дотоодын эдийн засгийн ажиллагаа саарснаар импортын хэмжээ огцом буурсан. 2009 оны эхний сарын үйцэтгэлийн өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын уналт 48 хувьтай байна. Харин экспорт дөнгөж 41 хувиар буурчээ.

Улирлын нөлөөллийг тусгах зорилгоор өмнөх 12 сарын гүйцэтгэлийг тооцож үзэхэд нийт экспорт 2,135 сая ам. доллар, нийт импорт 2,971 сая ам. доллар болжээ. Ингэснээр өмнөх 12 сарын гадаад худалдааны тэнцэл 4-р сард 989 сая м. долларын алдагдалтай байсан бол 5-р сард 836 сая ам.долларын алдагдалтай болж

2009 оны гүйцэтгэлийг 2008 оныхтой харьцуулахад экспорт буурсны гол шалтгаан нь зэс (зэсийн экспортын тоо хэмжээ маш бага буурсан ч үнийн бууралт илүү ихээр нөлөөлсөн), алт (тоо хэмжээ, үнийн аль аль нь буурсан) байсан бөгөөд харин нүүрсний экспорт өсөж, нийт импортыг

нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлсэн (Хүснэгт 3). 5-р сард зэс, алт, үүхий газрын тосны экспортод нааштай өөрчлөлт гарсны үр дүнд 2009 оны 4 -р сарын үйцэтгэлтэй харьцуулахад экспортын орлого бага зэрэгссөн. Гэхдээ экспортын тоо хэмжээ, нүүрсний үнэ буурсан . Дэлхийн зах зээл дээр зэс, цайр, түүхий нефтийн үнэ тодорхой хэмжээгээр сэргэж байна. Монгол Улсын экспортыг улс орноор нь эвэл БНХАУ, Европын холбооны экспорт 4 -р сарын үйцэтгэлтэй харьцуулахад тодорхой хэмжээгээр нэмэгджээ (Хүснэгт 4).

Хүснэгт 3. Барааны экспортод гарч буй өөрчлөлтийн гол хүчин зүйлүүд

	Экспортын орлого 2008 онд (сая ам. доллар)	2008 оны 4-р сараас 2009 оны мөн үе хүртэлх үнийн дүнгийн өөрчлөлт (%)	2008 оны 5-р сараас 2009 оны мөн үе хүртэлх үнийн дүнгийн өөрчлөлт (%)
Зэсийн баяжмал	835	-59.4	-58.7
Алт ⁽¹⁾	599	-35.8	-29.9
Нүүрс	184	129.7	61.6
Самнасан ноолуур ⁽²⁾	97	-25.6	-25.4
Боловсруулаагүй ноолуур ⁽³⁾	77	-4.6	-43.2
Цайрын баяжмал	154	-80.1	-68.7
Боловсруулаагүй газрын тос	101	-55.0	-43.5
Барааны нийт экспорт	2,539	-42.4	-40.6

(1) Хагас боловсруулсан хэлбэрээр. (2), (3) завсрын ноолууран бүтээгдэхүүн.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк

Хүснэгт 4. Экспорт, улс орноор

	Экспортын орлого 2008 онд (сая ам. доллар)	2008 оны эхний дөрвөн сараас 2009 оны мөн үе хүртэлх өөрчлөлт (%)	2008 оны эхний таван сараас 2009 оны мөн үе хүртэлх өөрчлөлт (%)
БНХАУ	1,644	-44.4	-43.0
Европын холбоо	435	2.3	15.9
Канад	175	-10.8	-23.9
АНУ	113	-92.0	-89.4
ОХУ	85	-29.1	-34.3
Барааний нийт экспорт	2,539	-42.4	-40.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк

2009 оны эхний таван сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад импорт 39.6 хувиар унаад байна (Хүснэгт 5). Төмөр, эрдэс баялгийн бүтээгдэхүүний импорт хамгийн их хэмжээгээр буурч хүнсний бараа, тоног төхөөрөмжийн импортын бууралт удаалж байна.

Хүснэгт 5. Барааны импортод гарч буй өөрчлөлтийн гол хүчин зүйлүүд

	Экспорт 2008 онд (сая ам. доллар)	2008 оны 4-р сараас 2009 оны мөн үе хүртэлх үнийн дүнгийн өөрчлөлт (%)	2008 оны 5-р сараас 2009 оны мөн үе хүртэлх үнийн дүнгийн өөрчлөлт (%)
--	--------------------------------------	---	---


Эрдэс баялгийн бүтээгдэхүүн	964	- 55.4	- 51.5
Машин тоног төхөөрөмж	606	- 19.6	- 28.5
Тээврийн тоног төхөөрөмж	459	- 22.1	- 26.0
Төмрөн эдлэл	267	- 67.1	- 66.4
Хүнсний бараа	231	- 29.4	- 33.0
Барааны нийт импорт	3,245	-37.8	-39.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш нилээд тогтвортой байж, Монголбанк гадаад валютын нөөцийн хуримтлал үүсгэхээр байлаа

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 4-р сарын сүүлээс хойш өөрчлөлтгүй шахуу байж, өдөртөө дунджаар 0.1 хувиар чангарч суларч 1,427 төгрөг орчимд тогтож байлаа. Энэ хугацаанд Монголбанкнаас ямар нэгэн интервенци хийгдээгүй. Ногдол ашиг, татварын тооцоог гадаад валютаар үйцэтгэж, алт худалдан авч, ханшийн тэгшитгэлийн үр нөлөөгөөр Монголбанкны гадаад валютын нөөц 4-р сарын эцэст 553 ам. долларт хүрч нэмэгдсэн байна. 4-р сарын эцэст 571 сая ам. доллар байсан банкны системийн гадаад валютын цэвэр нөөц 648 сая ам. долларт хүрчээ (Зураг 6).

Зураг 6. Төгрөгийн ханш тогтворжиж, Монголбанк гадаад валютын нөөцийн хуримтлал үүсгэхээр байв



Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк

4. Санхүүгийн салбар


Инфляци буурахтай зэрэгцээд Монголбанк бодлогын хүүгээ дахин бууруулав

4-р сарын инфляцийн жилийн өсөлт 12.6 хувьтай байсан бол 5-р сард 7.4 хувь болж огцом буурсан. Энэ нь суурь инфляци⁷ буурсантай шууд холбоотой бөгөөд эдийн засагт сааралт явагдаж байгаагийн нэг нотолгоо болж байна. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ мөн буурчээ (Зураг 7).

⁷ Суурь инфляцийг тооцоходоо үнийн өөрчлөлт ихтэй хүнсний бараа, түлшийг хамруулдаггүй бөгөөд дотоодын хүчин зүйлээр үүсэлтэй инфляцийн хэмжүүр болж өгдөг.

Зураг 7. Инфляци буурахтай зэрэгцээд Монголбанк бодлогын хүүгээ бууруулав

Жилийн өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк


Монголбанк бодлогын хүү буюу төвбанкны нэг долоо хоногийн үнэт цаасны хүүг 6-р сарын дундуур 12.75-аас 11.5 хувь болгож бууруулсан. Инфляцийн бууралттай харьцуулахад хүүг бага хэмжээгээр бууруулсан учраас одоо бодлогын хүү овоо өндөр эерэг утгатай болсон.

Нийт харилцах хадгаламж 4-р сараас 5-р сарын хооронд нэмэгдэв⁸

4-р сараас 5-р сарын хооронд арилжааны банкууд дахь нийт харилцах хадгаламж 13 тэрбум өгрөгөөр өссөн. Тухайлбал, төгрөгийн харилцах хадгаламж 43 тэрбум төгрөгөөр буурсан бол гадаад валютын харилцах хадгаламж 55 тэрбум өгрөгтэй тэнцэх хэмжээгээр нэмэгджээ (Зураг 8). Төгрөгийн харилцах хадгаламж ийнхүү буурсан нь өрлийнт харилцах хадгаламжинд гардаг улирлын өөрчлөлттэй нийцэж байна.

Зураг 8. Төгрөгийн харилцах хадгаламжийн хэмжээ буурч гадаад валютын харилцах хадгаламжийн хэмжээ өссөн

Тэрбум төгрөг, сарын өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк

Чанаргүй зээл, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл улам нэмэгдсэн

Зураг 9. Чанаргүй зээл, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн багц нэмэгдэж нийт зээлийн өрийн үлдэгдлийн 18.1 хувьд хүрсэн

Сая төгрөг

⁸ Энэ хэсэгт ашигласан тоо мэдээг Монголбанкнаас гаргаж өгсөн бөгөөд 2008 оны 12 -р сард Монголбанкнаас бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон Анод банкны мэдээг мөн багтаасан болно.



Тайлбар: Чанаргүй зээл, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн багцын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувийг дөрвөнжин доторх тоогоор харуулав.
Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк

Чанаргүй зээлийн багцын өсөлт үргэлжилж 294 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.6 хувьтай тэнцэж байна. Үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл⁹ мөн нэмэгдэж 165 тэрбум өпрөг (нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.5 хувь)-т үрчээ. Чанаргүй зээлийн багцүндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдлийн нийлбэр 459 тэрбум төгрөгт хүрч нийт зээлийн өрийн үлдэгдлийн 18.1 хувьтай тэнцэж байна (Зураг 9). Нийт чанаргүй зээлийн багцын 78 хувь хувийн хэвшилд оногдож байгаа бол хувь

хүмүүсийнх 22 хувьтай байна. Үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл үрүү шилжиж байгаа хэвийн зээлийн үлдэгдэл нэмэгдэж байгаа нь цаашид эрсдэл байгааг илтгэнэ.

Ихэнх салбаруудад олгосон зээлийн чанар муудсан ч зарим салбаруудад ил үү хүнд туссан

Чанаргүй зээлийн багц, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлд 2008 оны 4-р улирлаас 2009 оны нэгдүгээр улиралд гарсан өөрчлөлтийг салбарын бүтцээр нь авч үзвэл боловсруулах, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын зээл хамгийн ихээр мууджээ (Зураг 10а). 2009 оны нэгдүгээр улирлын байдлаар чанаргүй зээлийн багц, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдлийн ихэнх хэсэг гурван салбарт төвлөрчээ (Зураг 10б).


Зураг 10а. Боловсруулах салбар, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт олгосон зээлийн өрийн үлдэгдэл хамгийн өндөр чанаргүй багц, хугацаа хэтэрсэн үндсэн төлбөртэй байна

2008 оны 4-р улирал, 2009 оны 1-р улирлын хооронд чанаргүй зээлийн багц, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн өрөнд гарсан өөрчлөлт, хувиар


Зураг 10б. ... Тэгээд чанаргүй зээлийн багц, хугацаа хэтэрсэн зээлийн ихэнх хэсэг эдгээр салбарт ногдож байна.

2009 оны 1-р улирлын байдлаар чанаргүй зээлийн багц, үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээлийн нийт өрөнд эзлэх хувь, салбараар

⁹ Үндсэн төлбөр нь 1-90 хоног хугацаа хэтэрсэн зээл. 90 хонгөрсний дараа чанаргүй зээлийн багцад шилждэг.



Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк



Эх сурвалж: Монголбанк


Банкууд зээлээ хумивбанкны эрсдэл багатай үнэт цаасыг худалдан авч байна. Ингэснээр аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн зээл авах боломж маш хэцүү болж байна.

Банкуудын зээлийн олголт буурсаар зээлийн өрийн үлдэгдэл 2008 оны 6-р сарын үвшнээс доогуур оржээ. Хувь хүмүүс олгох зээлийн өсөлт сөрөг утгатай болсон (Зураг 11).

Зээл гаргахын оронд банкууд Монголбанкнаас төвбанкны үнэт цаас худалдан авч инфляци буурч байгаа энэ цагүед эрсдэлгүй бөгөөд өндөр өгөөж авч байна. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгжүүд банкнаас зээл авахдаа томоохон бэрхшээлтэй тулгарч байна. Монголбанкнаас энэхүү алагчилсан байдлыг арилгах үүднээс бодлогын хүүгээ бууруулсан билээ.

Зураг 11. Банкууд зээл гаргахын оронд төвбанкны үнэт цаасыг түлхүү худалдан авч байна

Жилийн өөрчлөлт, хувиар Жилийн өөрчлөлт, хувиар




Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банк

Хувийн хэвшлийн олон хэсэгт шинээр олгосон зээл буурсан

2008 оны нэгдүгээр улиралд 1,045 тэрбум төгрөгийн зээл шинээр гарч байсан бол 2009 оны эхний улиралд энэ үзүүлэлт 453 тэрбум төгрөг болж 57 хувиар багасчээ. 2008 оны нэгдүгээр улиралд Монгол Улсын эдийн засаг өндөр хурдацтай өсөж байсан юм. Бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхай олборлох, барилга, боловсруулах салбарт шинээр олгосон зээдлэмж буурчээ (Зураг 12а). Гэхдээ 2009 оны нэгдүгээр улирлын байдлаар банкуудын зээлийн нэгдсэн багц чанаргүй болоод үндсэн төлбөр нь хугацаа хэтэрсэн зээл өндөртэй салбаруудад төвлөрсөн хэвээр байна (Зураг 12б).

Зураг 12а. Бөөний болон жижиглэн худалдаа, уул уурхай, барилга, боловсруулах салбарт шинээр олгох зээл эрс багасч ...


Тэрбум төгрөг, шинээр олгосон зээл, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 12б. ... нийт зээлийн багцын ихэнх хэсэг чанаргүй зээлийн багц өндөртэй байгаа салбаруудад төвлөрч байна.

2009 оны 1-р улирлын байдлаарх зээлийн үлдэгдэлд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

5. Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдэл

Уул уурхай, олборлолтынүйл ажиллагаа бага зэрэг сэргэж байгаа шинж тэмдэг харагдаж байгаа ч зээл олголт багассан нь боловсруулах салбарын бууралт хадгалагдахад хүргэж байна

Зураг 13. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ерөнхий түвшин тогтвортой хэдий ч боловсруулах салбарт огцом уналт үргэлжилсээр байна

Жилийн бодит өөрчлөлт, хувиар, дараалсан гурван сарын дундаж



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн Банк

Дараалсан гурван сарын үйлдвэрийн бүтээгдэхүүний дундаж өмнөх онтой харьцуулахад 5.8 хувиар буурсан ч 4-р сарын үйцэтгэлтэй харьцуулахад бага зэрэг өссөн байна. Боловсруулах салбарын үйлдвэрлэл хумигдсаар байгаа бол түүхий нефть, нүүрсний үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотойгоор уул уурхай, олборлох салбар өсөлттэй гарч эхэллээ. Гэхдээ өрсрийн хүдэр, тэр дундаа зэсийн үйлдвэрлэлд ямар нэгэн өсөлт, бууралт ажиглагдахгүй байна. Цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл тогтвортой өсөлттэй байна (Зураг 13).

Аж ахуйн нэгжийн орлого, татвар төлөлт их хэмжээгээр буурлаа

Аж ахуйн нэгж байгууллагын эдийн засгийн салбараар ангилж 2008 оны 4-р улирал, 2009 оны 1-р улирлын тоо мэдээг аж ахуйн нэгжийн үвшинд авч үзэхэд эдийн засгийн саарал т тэдэнд хэрхэн тусаж байгаа нь тодорхой болж байна. Нэн ялангуяа, 2008 оны 4-р улиралд эрдэс баялгийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ 2004 оны үвшин болтол унахад уул уурхайн компаниудын татварынөмнөх ашиг эрс багас сан байна (түүнээс хойш тодорхой хэмжээний сэргэлт ажиглагдаж байна; Шигтгээ 2-ийг үзнэ үү).


Шигтгээ 2. Аж ахуйн нэгж байгууллагын орлого 2009 оны эхний улиралд өмнөх онтой харьцуулахад 64 хувиар буурсан

2008 оны цүүлчийн улирлаас эхлээд бараа түүхий эдийн үнэ, инфляци, ханш, эрэлтийнх зүйлс бодит салбарыг хүнд цохилтонд оруулж, аж ахуйн нэгжийн салбар томоохон уналтанд орсон. 2009 оны үзэр улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого 15.7 хувиар, өртөг зардал 8.3 хувиар тус тус буурчээ. Ингэснээр татварын өмнөх ашиг 64.4 хувиар, татвар өлөлт 60.7 хувиар тус тус буурчээ (Зураг 14).^a

Барилга, үл хөдлөх хөрөнгийн зээл олголт буурч, эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ 2004 оны түвшинд хүртэл унаж, эдийн засгийн үргэлжлэсэн гэж холбоотойгоор барилга, уул уурхай, хий, үлш, нүүрсний бөөний худалдааны аж ахуйн нэгжүүдийн борлуулалт их хэмжээгээр буурсан (Зураг 15). 2008 оны эхний улиралтай харьцуулахад эрчимч хий, түлш болон нүүрсний бөөний худалдаа, тээврийн салбарууд хамгийн өндөр алдагдал хүлээсэн байна. Нийт зардлын 30 хувийг үнийн өсөлт эзэлж, мөн орлого буурсан нь ийм үр дагавар авчирсан. Аж ахуйн

Зураг 14. Аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого, татварын өмнөх ашиг, татвар төлөлт буурсан


2009 оны 1-р улирлын 2008 оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: 180 томоохон аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, Үндэсний татварын ерөнхий газар, Дэлхийн Банк

Зураг 15. Барилга, уул уурхай, хий, түлш, нүүрсний бөөний худалдааны аж ахуйн нэгжүүдийн орлого хамгийн ихээр унажээ

2009 оны 1-р улирлын 2008 оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт, хувиар



180 томоохон аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан
Эх сурвалж: Үндэсний татварын ерөнхий газар

нэгжүүдийн үйл ажиллагаа багасч байгаа нь цаашид ажилгүйдэл, төсвийн орлого, нийт эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Эх сурвалж: Үндэсний татварын ерөнхий газар, Дэлхийн Банк


^a Улсын төсвийн аж ахуйн нэгж байгууллагын орлогын татварын 80 хувийг бүрдүүлдэг 180 томоохон аж ахуйн нэгжийн орлогын нэгдсэн тайлангийн дүнгээр.

Албан болон албан бус секторын аль алинд ажилгүйдэл нэмэгдсэн

2009 оны 5-р сарын өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 20.4 хувиар нэмэгдэж бүртгэлтэй ажилгүйдлийн түвшин нийт ажиллах хүчний 3.6 хувьд хүрлээ (Зураг 16). Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлээгүй, ажил идэвхтэй хайж байгаа болон шууд ажил хийх боломжтой ажилгүйчүүдийн тоо мэдээ энэ үзүүлэлтэнд тусгагдаагүй учраас ажилгүйдлийн дүр зургийг бүрэн дүүрэн харуулж чадахгүй юм. Ажилгүйдлийн бодит түвшин ажиллах хүчний 9-12 хувь байх магадлалтай байна.¹⁰ Албан бус секторын талаар сүүлд хийсэн судалгааны үр дүнгээр эдийн засгийн сааралт Монгол Улсын нийгэм, ядуурлыг байдал өргөн хүрээнд нөлөөлж байна гэсэн дүгнэлт гарчээ (Шигтгээ 3).¹¹

Зураг 16. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо эрс өсөв

Ажиллах хүчинд эзлэх хувь



* Одоогоор цалинтай ажил эрхлээгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, ажил идэвхтэй хайж байгаа, Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй хөдөлмөрийн насны хүмүүс үүнд хамаарна.

** Дараалсан 12 сарын ажилгүйчүүдийн тооны дундажийг шугаман интерполяцийн аргаар тооцоолсон ажиллах хүчний тоонд хуваах замаар улирлын нөлөөллийг тохируулсан.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Дэлхийн

¹⁰ Бүртгэгдээгүй ажилгүйчүүдийн тоог ҮСХ-ноос удахгүй нийтлэхээр төлөвлөж байна.

¹¹ Энэ судалгааг Дэлхийн Банкны захиалгаар Улаанбаатарт төвтэй Global Reach ТББ гүйцэтгэсэн.

Банк

Шигтгээ 3. Монгол Улсын эдийн засгийн сааралтын нийгэм, ядуурлын үр дагавар

Хямралын өрхийн амьжиргааны үр дагаварт саяхан хийсэн судалгааны урьдчилсан дүнгээр хөдөө орон нутгийн албан бус секторт ажиллаж буй ажилчдын хувьд өдөр эрхлэлтийн нөхцөл илүү таагүй болж байна.^b Эдийн засгийн өжцөл байдал муудаж, ажил хомсдон, цалин хөлс буурч, амьжиргааны өртөг нэмэгдсэн нь малчид, албан бус уул уурхайд ажиллагчдын байдал хүндэрч байна.

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ү нэ тогтворгүй байснаас малчдын орлого эрс буурсаныг судалгаагаар тогтоожээ. Малчид ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, арьсүүмэжүүв бүтээгдэхүүнийг худалдан борлуулснаас ихэнх орлогоо бүрдүүлдэг. Гэтэл зах зээлийн үнэ буурч, өртөг зардал нь нэмэгдсэнээс (Хүснэгт 6) малчид банкны зээлээ эргэн төлөхийн тулд малаа зарж борлуулан амьжиргаагаа тэгтэхэд хүрэхтэй үгүйтэй үлдэж байна. Судалгаанд хамрагдсан зарим орон нутагт өрхийн тал хувь нь банкны зээлийн өртэй хэвээр байна. Ийм нөхцөл байдалд мал чид чинээлэг малчинд өжсөөр ажиллах, албан бус уул уурхай эрхлэх зэргээр орлогоо эрх үүсвэр хайж, зарим нь ямар нэгэн ажил хийхээр хотыг зорьж байна.

Албан бус уул уурхайд ажиллаж буй 64 мянга гаруй мүүс буюу нинжа нарын хувьд алтыг ялгаж авахад хэрэглэхэд химийн бодис материалын өртөг 2008 оны 9 -р сард 65-70 мянган төгрөг байдаг байсан бол 2009 оны 6-р сарын байдлаар 115-120 мянган төгрөг болж өсчээ (Хүснэгт 7). Алтны үнэ өссөн хэдий ч олборлох үйл ажиллагаа, хоол хүнс, тээврийн өртөг зардал нэмэгдс ээр байна. Албан бус уул уурхай эрхлэгчдийн хувьд алт ухахаа өөр орлого олох боломж, ажил байхгүй байна. Нинжа, малчдын аль алинд хүүхдийн болоод тэтгэврийн мөнгө нь буурч байгаа орлого, өсөн нэмэгдэж буй зардлын зөрүүг нөхөх орлогын чухал эх үүсвэр болж байна. Мөн тэд нар банкаас зээл авч, эдийн засгийн энэ хүнд үеийг даван туулж шинээр бизнес эрхлэх найдлага дүүрэн байна.

Хүснэгт 6. Хүнсний барааны үнэ өссөн

	2008 оны 9-р сараас 2009 оны 6-р сарын хооронд өөрчлөгдсөн байдал (%)
Цагаан будаа	100
Гурил	150
Элсэн чихэр	50

Хүснэгт 7. Газрын тосны үнэ буурч албан бус уул уурхайн зарим өртөг зардлын өсөлтийг хязгаарлав

	2008 оны 9-р сараас 2009 оны 6-р сарын хооронд үнэ өөрчлөгдсөн байдал (%)
Химийн бодис	71
Газрын тос	-42

Эх сурвалж: Хямралын өрхийн амьжиргаанд үзүүлсэн үр нөлөөний судалгаа (2009 оны 5-р сарын 20–6-р сарын 15), Global Reach, Дэлхийн Банк

^b Энэ судалгааны ажлыг Дэлхийн Банкны захиалгаар Улаанбаатарт төвтэй Global Reach ТББ гүйцэтгэв.

6. Дүгнэлт

Эдийн засгийн сааралтын үр нөлөө эдийн засгийн бүх салбарт мэдрэгдэж, банкны салбарт томоохон эрсдэлүүд тулгараад байна. Эдийн засаг тогтворжиж байгаагийн шинж тэмдэг илэрч байна. Тухайлбал, өсвийн алдагдал тодорхой хязгаарт баригдах болж, гадаад худалдааны алдагдал багасч, төгрөгийн ханш тогтворжилоо. Засгийн газар цаашид аж ахуйн нэгж байгууллага, банкны салбарт гарах өөрчлөлт хөгжлийг нягт хянаж, эдийн засгийн сааралтын ядуу, эмзэг бүлэгт үзүүлэх нөлөөллийг хязгаарлах нь зүйтэй.

Хүснэгт 8. Монгол Улсын үндсэн үзүүлэлтүүд

	2003	2004	2005	2006	2007	2008 ХБГ	2009 төс.
Үйлдвэрлэл, ажил эрхлэлт, үнэ							
Бодит ДНБ (жилийн өөрчлөлт, хувиар)	7.0	10.6	7.3	8.6	10.2	8.9	2.7
аж үйлдвэрийн индекс	100.0	110.4	113.4	..
(жилийн өөрчлөлт, хувиар)	10.4	2.8	..
Ажилгүйдэл (%)	3.4	3.6	3.3	3.2	2.8	2.8	..
Хэрэглээний үнийн индекс (жилийн өөрчлөлт, хувиар)	4.6	10.9	9.6	5.9	14.1	23.2	9.0
Улсын салбар							
Төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	-3.7	-1.8	2.6	8.1	2.8	-5.0	-6.0
Эрдэс баялгийн бус тэнцэл (ДНБ-д эзлэх хувь) ⁽¹⁾	-5.9	-5.8	-1.3	-7.3	-13.4	-15.3	-10.4
Улсын салбарын дотоод өр (ДНБ-д эзлэх хувь)	3.1	1.4	0.1	1.0	0.5	0.0	0.0
Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, гадаад өр							
Худалдааны тэнцэл (сая ам. доллар)	-199.6	-99.2	-99.5	136.2	-52.4	-596.5	-331.0
Exports of goods (сая ам. доллар)	627.3	872.1	1066.1	1543.9	1950.7	2532.5	1863.0
(жилийн өөрчлөлт, хувиар)	19.7	39.0	22.2	44.8	26.4	29.8	-26.4
Зэсийн экспорт (жилийн өөрчлөлт, хувиар)	14.7	94.8	27.7	3.0	..
Барааны импорт (сая ам. доллар)	826.9	971.3	1165.6	1407.7	2003.1	3128.9	2194.0
(жилийн өөрчлөлт, хувиар)	21.6	17.5	20.0	20.8	42.3	56.2	-29.9
Урсгал дансны тэнцэл (сая ам. доллар) ⁽²⁾	-102.4	24.1	29.7	221.6	264.8	-502.7	-261.8
(ДНБ-д эзлэх хувь)	-7.1	1.3	1.3	7.0	6.7	-9.6	-6.5
Гадаад хөрөнгө оруулалт (сая ам. доллар)	131.5	128.9	257.6	289.6	360.0	682.5	316.5
Гадаад өр (сая ам. Доллар)	1240.3	1311.8	1360.0	1413.9	1528.7	1600.5	1795.8
(ДНБ-д эзлэх хувь)	87.3	73.7	59.7	44.3	38.9	33.1	46.8
Богино хугацааны өр (сая ам. доллар) ⁽³⁾	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	..
Өрийн үйлчилгээний харьцаа (бараа үйлчилгээний экспортод эзлэх хувь) ⁽³⁾	13.4	9.4	7.6	5.4	4.3	3.5	4.3
Гадаад валютын нөөц, нийт (сая ам. доллар)	203.5	207.8	333.1	718.0	1,000.6	656.7	822.1
(бараа үйлчилгээний импортын	2.3	1.8	2.5	4.6	5.0	2.1	3.7

сараар)

Санхүүгийн зах

Дотоод зээл (жилийн өөрчлөлт, хувиар)	157.3	25.8	18.8	-3.1	78.4	60.6	..
Богино хугацаатай хүүгийн түвшин (хувиар, жилд) ⁽⁴⁾	..	15.8	3.7	5.1	8.4	9.8	..
Ханш (төгрөг/ам. доллар, хугацааны эцэст)	1168.0	1209.0	1221.0	1165.0	1170.0	1267.5	1640.0
Үйлчилж буй бодит ханш (2000=100) ⁽⁵⁾	96.9	95.4	101.8	107.1	109.0	130.2	..
(жилийн өөрчлөлт, хувиар)	-4.8	-1.5	6.7	5.2	1.8	19.5	..
Хөрөнгийн захын индекс (2000=100) ⁽⁶⁾	151.5	120.8	203.6	382.0	2048.0	1181.6	..
Суурь үзүүлэлтүүд:							
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөг)	1,660	2,152	2,780	3,715	4,600	6,130	6,294
Нэрлэсэн ДНБ (сая ам. доллар)	1,448	1,814	2,307	3,156	3,930	5,258	4,035

(1) Эрдэс баялгийн бус орлогод уул уурхайн компаниудын аж ахуйн нэгжийн орлогын татвар, ногдол ашгийн төлбөр, гэнэтийн ашгийн татвар, нөц ашигласны төлбөрүүд багтаагүй . (2) гадаад секторын 2009 оны төсөөллийг гаргахдаа урсгал дансны 2008 оны үйцэггэлийн үзүүлэлти йн (тайланд дурьдагдсан байгаа) оронд өмнөх тооцоог ашигласан. (3) улсын болон засгийн газрын баталгаатай өр . (4) 2006 оныг хүргэл 14 хоногийн үнэт цаасны өгөөж, 2007 онд 7 хоногийн үнэт цаасны хүү. (5) Өсөлт нь ханш чангаралтыг илэрхийлнэ. (6) ТОП-20 индекс, хугацааны эцэст, 2000 оны 12-р сард индекс=100.

Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, ОУВС, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо судалгаа